# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

---

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

# АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДТАЙ БАЙГУУЛСАН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН




Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд болон нутгийн захиргааны байгууллагуудын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээ, хандив тусламж нь холбогдох хууль, эрхийн актуудыг зөрчиж байна.

**Сүхбаатар сум**

**2020 он**

**Тайланг бэлтгэсэн:**

**Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар**

**Дарга, тэргүүлэх аудитор**
Ч.Энхтуяа
**Аудитын менежер**
Б.Батмөнх
**Ахлах аудитор**
А.Дашбат
**Аудитор**
О.Анхбаяр

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл гарвал 70362442, 70363047, 70363040 дугаарын утас, Selenge@audit.gov.mn цахим сайтаар харилцана уу.

**ХАЯГ:**Сэлэнгэ аймгийн, Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ-ын байрны өргөтгөлд

2020 оны 5-6 дугаар сар

## АГУУЛГА

**Товчилсон үгийн жагсаалт**
**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**
**Үндсэн мэдээлэл**

**Бүлэг 1. Ашигт малтмалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн 63.2 хүртэлх хувь нь нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд гэрээнд тусгагдсан төсөл, арга хэмжээний 97.3 хувийг хэрэгжүүлсэн байна.**

**1.1.** Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын 36.8-73.7 хувь /2017 онд 73.7 хувь, 2018 онд 53.3 хувь, 2019 онд 36.8 хувь/ нь хамтран ажиллах гэрээ байгуулаагүй байна.

**1.2** 4 аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээнд тусгагдсан 74.0 сая төгрөгийн өртөг бүхий 4 ажил төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

**Бүлэг 2. Нийт хандив, тусламжийн 85.9 хувь нь Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-д заасан зорилго, агуулгатай нийцээгүй байна.**

**2.1.** Хандив, тусламжийн орлогыг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлээгүй байна.

**2.2.** Хандив, тусламжийн орлогыг холбогдох хууль, эрхийн актын дагуу зарцуулаагүй байна.

**Илрүүлсэн зөрчил**
**Дүгнэлт**
**Зөвлөмж**
**Хавсралт судалгаа**

# ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| **АДБОУС** | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| **БОАЖГ** | Байгаль, орчин, аялал жуулчлалын газар |
| **ГҮТББ** | Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага |
| **ЗДТГ** | Засаг даргын Тамгын газар |
| **ЗӨСТ** | Зоонозын өвчин судлалын төв |
| **ИТХ** | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| **ОБГ** | Онцгой байдлын газар |
| **ОНХС** | Орон нутгийн хөгжлийн сан |
| **ОНӨААТҮГ** | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| **ОҮИТБС** | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга |
| **ТББ** | Төрийн бус байгууллага |
| **ТБОНӨХБАҮХА** | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах |
| **ХК** | Хувьцаат компани |
| **ХХК** | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

**Аудитын зорилт:**

Сэлэнгэ аймагт ашигт малтмалын олборлох үйлдвэрлэл эрхэлж байгаа, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд болон нутгийн захиргааны байгууллагуудын хооронд байгуулсан гэрээ, хандив тусламжийн хууль, эрх зүйн үндэслэл, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт оршлоо.

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь холбогдох хууль, журмын дагуу орон нутгийн захиргааны байгууллагуудтай гэрээ байгуулан, хэрэгжүүлж байна уу?
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс хууль, журмын хүрээнд хандив, тусламжийн орлого төвлөрүүлэн, зарцуулж байна?

**Аудитын хамрах хүрээ:**

Аудитыг Сэлэнгэ аймагт 2017-2019 онд ашигт малтмалын олборлох үйлдвэрлэл эрхэлсэн аж ахуйн нэгжүүдийн нутгийн захиргааны байгууллагуудтай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээ, гэрээний дагуу хүлээн авсан хандив, тусламж, түүний зарцуулалтын тайлан, мэдээ, судалгаа болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

**Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журам, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аймгийн ЗДТГ, ОБГ, сумдын ИТХ, ЗДТГ, бусад төр, төсвийн байгууллага, хандив тусламж өгсөн уул уурхайн компаниудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, санхүүгийн тайлан, мэдээ, бусад шаардлагатай баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын тайлан, дүгнэлтэд дэмжлэг болох нотолгоо, холбогдох судалгааг хавсаргав.

**Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:**

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Ашигт малтмалын тухай хууль;
- ТБОНӨХБҮХА тухай хууль;
- Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоолоор баталсан "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай" тогтоол;
- Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор баталсан ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ"-ний загвар;
- Сангийн сайдын 2016 оны 43 дугаар тушаалаар баталсан "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тайлангийн маягт .... нөхөх заавар";
- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-05 дугаар тушаалаар баталсан "Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, боловсруулж, хянан батлах, тайлагнах журам";
- Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам";
- Аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан хамтран ажиллах гэрээнүүд;
- Бусад холбогдох хууль тогтоомж, эрхийн актууд.

**Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:**

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор А.Дашбат, аудитор О.Анхбаяр нар 2020 оны 05 дугаар сарын 11-нээс 07 дугаар сарын 01-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

**Үндсэн мэдээлэл:**

2019 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын хэмжээнд 2101 аж ахуйн нэгж, байгууллага ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын 3266 тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаагаас Сэлэнгэ аймагт ашиглалтын 137, хайгуулын 36 зөвшөөрөл эзэмшигч 132 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байна.

**Хүчин төгөлдөр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо, талбайн хэмжээг 2017-2019 оны байдлаар нэгтгэн харуулбал:**

Хүснэгт №1

| Огноо | Ашиглалтын тусгай зөвшөөрөл | | | Хайгуулын тусгай зөвшөөрөл | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Эзэмшигчийн тоо | Зөвшөөрлийн тоо | Талбайн хэмжээ /мян.га/ | Эзэмшигчийн тоо | Зөвшөөрлийн тоо | Талбайн хэмжээ /мян.га/ |
| 2017 он | 95 | 133 | 41.0 | 30 | 33 | 50.3 |
| 2018 он | 97 | 135 | 41.9 | 31 | 34 | 50.4 |
| 2019 он | 99 | 137 | 46.2 | 33 | 36 | 52.8 |

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй нийт газар нутгийн 46.7 хувийг ашиглалтын, 53.3 хувийг хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газар нутаг эзэлж байна.

Үүнээс 2017-2019 оны хооронд идэвхтэй үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийн тоог тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн тоотой харьцуулан харуулбал:

График-1




*2017-2019 онд Сэлэнгэ аймагт бүртгэлтэй нийт 132 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 14.4 хувь нь буюу 25 аж ахуйн нэгж, байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулсан байна.*

Сэлэнгэ аймгийн төр, захиргааны байгууллагуудад 2017-2019 онуудад тусгай зөвшөөрөл эзэмшигч 36 аж ахуйн нэгж, байгууллагаас нийт **4,425.6** сая төгрөгийн мөнгөн болон мөнгөн бус / *хөрөнгөөр* / хандив, тусламж олгосон байна.

Нийт хандив, тусламжийн 30.2 хувь буюу 1,335.0 сая төгрөгийг мөнгөн, 69.8 хувь буюу 3,090.6 сая төгрөгийг мөнгөн бус хандив, тусламж эзэлж байна. */Дэлгэрэнгүйг хавсралт №1-д харуулав/*

***Бүлэг 1***

**Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь холбогдох хууль, журмын дагуу орон нутгийн захиргааны байгууллагуудтай гэрээ байгуулан, хэрэгжүүлж байна уу ?**

*Ашигт малтмалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн 63.2 хүртэлх хувь нь нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд гэрээнд тусгагдсан төсөл, арга хэмжээний 97.3 хувийг хэрэгжүүлсэн байна.*

### ***1.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь холбогдох хууль, журмын дагуу орон нутгийн захиргааны байгууллагуудтай гэрээ байгуулж байна уу?***

*Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын 36.8-73.7 хувь / 2017 онд 73.7 хувь, 2018 онд 53.3 хувь, 2019 онд 36.8 хувь / нь хамтран ажиллах гэрээ байгуулаагүй байна.*

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 (ж)-д *“Бүс нутгийн болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй хамтран ажиллах тухай гэрээ, хөтөлбөр, бусад баримт бичгийг батлах”*, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д *“Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана”* гэж тус тус заасан байдаг.

Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудаас 2017 онд 5, 2018 онд 7, 2019 онд 12 компани аймаг, сумын төр, захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах 26 гэрээ байгуулсан байна. Үүнд:

- ***Сэлэнгэ аймаг:*** *2019 онд “Ди Зэт Энд Ай” ХХК, “Эрдэс групп” ХХК, “Шар нарст” ХХК, “Болд төмөр ерөө гол” ХХК, “Олз газар” ХХК, Тайхаржин майнинг” ХХК, “Сонор трейд” ХХК, “Бейсик метал майнинг” ХХК зэрэг 8 компанитай;*
- ***Мандал сум:*** *2018 онд “Бороо гоулд” ХХК, “Демси трейд” ХХК, 2019 онд “Бороо гоулд” ХХК, “Демси трейд” ХХК-тай;*
- ***Баянгол сум:*** *2017 онд “Тод ундрага” ХХК, 2018 онд “Тод ундрага” ХХК, “Сонор трейд” ХХК, “Сэлэнгэ байгалийн нөөц” ХХК, “Хонгорын орд” ХХК, 2019 онд “Хонгорын орд” ХХК, “Бороо гоулд” ХХК-тай;*
- ***Орхонтуул сум:*** *2017 онд “Өгөөж баян хангай” ХХК, 2019 онд “Бийд Майнинг” ХХК-тай;*
- ***Хүдэр сум:*** *2017-2019 онд “Бейсикметал майнинг” ХХК, 2017 онд “Эрдэс групп” ХХК, “Дархан төмөрлөг” ХХК-тай;*
- ***Түшиг сум:*** *2019 онд “Шар нарст” ХХК-тай.*

**2017-2019 онуудын гэрээний хамрагдалтыг графикаар харуулбал:**

График-2




Дээрх графикаас харахад 2017-2019 онуудад Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын 26.3-63.2 хувь /*2017 онд 26.3 хувь, 2018 онд 46.7 хувь, 2019 онд 63.2 хувь*/ нь нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулсан байна. Өөрөөр хэлбэл Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг хангалтгүй хэрэгжүүлж, тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын 36.8-73.7 хувь /*2017 онд 73.7 хувь, 2018 онд 53.3 хувь, 2019 онд 36.8 хувь*/ нь хамтран ажиллах гэрээ байгуулаагүй байна.

2017-2019 онд Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулсан ч орон нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж, ажиллаагүй дараах компаниуд байна. Үүнд:

- **2017 он:** *“Уулс ноён” ХХК, “Болд төмөр ерөө гол” ХХК, “Ди Зэт Энд Ай” ХХК, “Бүүргэнт” ХХК, “Ганбаттулга” ХХК, “Инфинити спейс” ХХК, “Толгойтын гол” ХХК, “Бороо гоулд” ХХК, “Пентатерра” ХХК, “Тайхаржин Майнинг” ХХК, “Демси трейд” ХХК, “Хөтөлийн цемент шохой” ХХК, “Шар нарст” ХХК;*
- **2018 он:** *“Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК, “Болд төмөр ерөө гол” ХХК, “Ди Зэт Энд Ай” ХХК, “Ганбаттулга” ХХК, “Толгойтын гол” ХХК, “Пентатерра” ХХК, “Тайхаржин майнинг” ХХК, “Хөтөлийн цемент шохой” ХХК, “Шар нарст” ХХК;*
- **2019 он:** *“Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК, “Бэрлэг майнинг” ХХК, “Капитал авто сервис” ХХК, “Инфинити спейс” ХХК, “Пентатерра” ХХК, “Тод ундрага” ХХК, “Хөтөлийн цемент шохой” ХХК зэрэг.*

Харин 2017-2019 онд үйл ажиллагаа явуулаагүй “Аполло Капитал” ХХК нь Мандал сумын, “Флинк монголия” ХХК нь Орхонтуул сумын, “Редхил монголия” ХХК-ийн зөвшөөрөл дээр туслан гүйцэтгэгчээр ажилласан “Техно преспектив” ХХК нь Түшиг сумын орон нутгийн захиргааны байгууллагуудтай гэрээ байгуулан, хамтран ажилласан байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-д *“Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана”* гэж заасан байдаг. Гэтэл ашигт

малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагуудын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний ихэнх нь дээрх чиглэлээр бус хөрөнгө оруулалт, урсгал засвар, тохижилт, эд хогшил худалдан авах, баяр ёслол, ойн арга хэмжээ тэмдэглэх зэрэг чиглэлээр хийгдсэн байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "*Ашигт малтмалын асуудлаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.1.10.энэ хуулийн 42.1-д заасан гэрээний загварыг батлах*" гэж заасны дагуу Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах *"Байгаль орчныг хамгаалах, уурхайг ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ"*-ний загварыг баталсан байна.

Аудитын явцад 18 тусгай зөвшөөрөл эзэмшигч, 1 туслан гүйцэтгэгч компанийн 2017-2019 оны хооронд орон нутгийн захиргааны байгууллагуудтай байгуулсан хамтран ажиллах 26 гэрээг дээрх гэрээний загвартай тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Харилцагч талуудын эрх, үүрэг, нийтэд мэдээлэх танилцуулах, сургалт хөтөлбөр, ажлын байраар хангах, гамшгийн үеийн тусламжтай холбоотой 2-3 дахь заалтуудыг зөрчсөн:

  - ➢ *Хүдэр сумын Засаг даргын "Бейсикметал майнинг" ХХК, "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК, "Эрдэс групп" ХХК-уудтай байгуулсан 3 гэрээнд харилцагч талуудын эрх, үүрэгтэй холбоотой заалтуудыг бүрэн тусгаагүй;*
  - ➢ *Мандал сумын Засаг даргын "Бороо гоулд" ХХК, "Аполло Капитал" ХХК-уудтай байгуулсан 3 гэрээ, Баянгол сумын Засаг даргын "Бороо гоулд" ХХК-тай байгуулсан гэрээнд гэрээний хэрэгжилтийг иргэдэд мэдээлэхтэй холбоотой 2.1.3 дахь заалтыг тусгаагүй,*
  - ➢ *Мандал сумын Засаг даргын "Бороо гоулд" ХХК, "Аполло Капитал" ХХК-уудтай байгуулсан гэрээнд сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулахтай холбоотой 3.1.3 дахь заалтыг тусгаагүй;*
  - ➢ *Мандал сумын Засаг даргын "Бороо гоулд" ХХК, "Аполло Капитал" ХХК-уудтай, Баянгол сумын Засаг даргын "Бороо гоулд" ХХК-тай Түшиг сумын Засаг даргын "Шар нарст" ХХК, "Техно преспектив" ХХК-уудтай байгуулсан гэрээнд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангахтай холбоотой 3.1.4 дэх заалтыг тусгаагүй;*
  - ➢ *Сэлэнгэ аймгийн Засаг даргын "Ди Зэт Энд Ай" ХХК, "Эрдэс групп" ХХК, "Шар нарст" ХХК, "Болд төмөр ерөө гол" ХХК, "Олз газар" ХХК, Тайхаржин майнинг" ХХК, "Сонор трейд" ХХК, "Бейсик метал" ХХК-уудтай байгуулсан 8 гэрээнд гамшгийн үед тусламж үзүүлэхтэй холбоотой 3.1.9 дэх заалтыг тусгаагүй байна.*

- Гэрээ байгуулах явц, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий “Хамтын ажиллагааны хороо”-г байгуулж, ажиллуулах талаар заасан 4 дэх заалтыг зөрчсөн:

  - ***Сэлэнгэ аймаг:*** *2019 онд “Ди Зэт Энд Ай” ХХК, “Эрдэс групп” ХХК, “Шар нарст” ХХК, “Болд төмөр ерөө гол” ХХК, “Олз газар” ХХК, Тайхаржин майнинг” ХХК, “Сонор трейд” ХХК, “Бейсик метал” ХХК-уудтай байгуулсан 8 удаагийн гэрээнд;*
  - ***Мандал сум:*** *2018 онд “Демси трейд” ХХК, 2019 онд “Аполло Капитал” ХХК, “Демси трейд” ХХК зэрэг 3 удаагийн гэрээнд;*
  - ***Хүдэр сум:*** *2017 онд “Бейсикметал майнинг” ХХК, “Эрдэс групп” ХХК, “Дархан төмөрлөг” ХХК-уудтай байгуулсан 3 удаагийн гэрээнд тус тус “Хамтын ажиллагааны хороо”-г байгуулж, ажиллуулах заалтыг тусгаагүй.*

- Гэрээний хэрэгжилтийг тайлагнах, гэрээний үүргийн биелэлттэй холбоотой хариуцлагын талаар заасан 5, 6 дугаар заалтыг зөрчсөн:

  - *Хүдэр сумын Засаг даргын 2017 онд “Бейсикметал майнинг” ХХК, “Эрдэс групп” ХХК, “Дархан төмөрлөг” ХХК-уудтай байгуулсан 3 удаагийн гэрээнд гэрээ байгуулсан болон дүгнэсэн талаар мэдээлэх, гэрээний хэрэгжилтээр хүлээх хариуцлага зэрэг 5.1-5.3 дахь заалтууд огт тусгагдаагүй байна.*

### *1.2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон орон нутгийн захиргааны байгууллагуудын хооронд байгуулсан гэрээг хэрэгжүүлэн ажиллаж байна уу?*

*4 аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээнд тусгагдсан* ***74.0*** *сая төгрөгийн өртөг бүхий 4 ажил төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.*

Засгийн газрын 2012 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” 222 дугаар тогтоолын 11 дүгээр зүйлд ” *тухайн нутаг дэвсгэрт ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжээс .... өгсөн хандив тусламжийг нийтэд мэдээлэх, уг ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд хороо” байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавин, олборлогч аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээ, хэрэгжилтийг нийтэд ил тод мэдээлэх*” зэрэг арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосон байдаг.

Дээрх тогтоолын дагуу дараах орон тооны бус дэд хороог байгуулсан байна. Үүнд:

- *Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/12 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр,*
- *Орхонтуул сумын Засаг даргын 2015 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/77 дугаар захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр;*
- *Ерөө сумын Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 226 дугаар захирамжаар 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулсан байна.*

Харин ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл ихтэй Баянгол, Мандал, Түшиг, Хүдэр зэрэг сумд дэд хороо байгуулаагүй байна.

Дээр дурдсанаар 2012 онд дэд хороо байгуулан ажиллах тухай Засгийн газрын шийдвэр гарсан байхад аймаг болон 2 сум 2015-2018 онд дэд хороо байгуулсан, 4 сум өнөөг хүртэл байгуулаагүй, дэд хороод нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, орон нутгийн захиргааны байгууллагын хооронд хийгдсэн гэрээ, түүний хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд хяналт хийгээгүй, олон нийтэд мэдээлээгүй байна.

Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээний загвар”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д “*Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороог Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна*”, 4.2-т *“Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө*” гэж тус тус заасан байдаг.

2017-2019 оны хооронд нийт 19 компанитай 26 гэрээ байгуулсны 12 гэрээнд Хамтын ажиллагааны хороог байгуулж, ажиллуулах заалтыг тусгасан ч Баянгол сум 4 компанитай, Орхонтуул сум 2 компанитай, Түшиг сум 2 компанитай байгуулсан гэрээний дагуу хороог байгуулаагүй байна. Үүнд:

- *Баянгол сумын Засаг дарга 2017 онд “Тод ундрага” ХХК, 2018 онд “Сонор трейд” ХХК, “Сэлэнгэ байгалийн нөөц” ХХК, “Хонгорын орд” ХХК-уудтай;*
- *Орхонтуул сумын Засаг дарга 2017 онд “Өгөөж баян хангай” ХХК, “Флинк монголиа” ХХК, “Бийд майнинг” ХХК-уудтай;*
- *Түшиг сумын Засаг дарга 2019 онд “Шар нарст” ХХК, “Техно преспектив” ХХК-уудтай тус тус байгуулсан гэрээнд,*

Харин Мандал сум, Баянгол сумд “Бороо гоулд” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу Хамтын ажиллагааны хороог байгуулсан байна. Үүнд:

- **Мандал сум:** *Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 53 дугаар тогтоолоор хамтран ажиллах гэрээ байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргаар ахлуулсан 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бол сумын Засаг даргын 2018 оны 279 дүгээр захирамжаар орон нутгийн захиргааны зүгээс*

*төсөл хөтөлбөрийг сонгох, зарцуулалтад хяналт тавих ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр, "Бороо гоулд" ХХК-ийн ерөнхий менежерийн 2018 оны 53/18 дугаар тушаалаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлсөн ажлын хэсгийг 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр;*

- **Баянгол сум:** *Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 10 дугаар тогтоолоор гэрээ хэлэлцээр хийхэд орон нутгийн захиргааны байгууллагыг төлөөлөх ажлын хэсгийг сумын Засаг даргаар ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бол сумын Засаг даргын 2019 А/102 дугаар захирамжаар гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр, "Бороо гоулд" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2019 42/19 дүгээр тушаалаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлсөн ажлын хэсгийг 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулсан байна.*

Мандал сумын Хамтын ажиллагааны хороо нь 2018 онд нийтдээ 4 удаа хуралдаж, хамтын ажиллагааны хорооны дүгнэлтийн дагуу 30.0 сая төгрөгийг 1 төсөл, арга хэмжээнд, 2019 онд 1 удаа хуралдаж, хамтын ажиллагааны хорооны дүгнэлтийн дагуу 40.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээнд тус тус дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн байна. Үүнд:

- *2018 он: Мандал сумын төв доторх замын ажилд 30.0 сая төгрөгийг;*
- *2019 он: 50-р байрны засварт 15.0 сая төгрөг, Түнхэл тосгоны үерийн далан байгуулахад 10.0 сая төгрөг, Атар газар эзэмшсэний 60 жилийн ойн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажилд 15.0 сая төгрөгийг тус тус зарцуулахаар баталсан байна.*

Аудитын явцад дээрх ажлуудын хэрэгжилтийг тулган баталгаажуулахад 50-р байрны засварын ажил, Түнхэл тосгоны үерийн далангийн ажлууд дуусаагүй, Атар газар эзэмшсэний 60 жилийн ойн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил бүрэн хэрэгжсэн байна.

Баянгол сумын Хамтын ажиллагааны хороо нь 2019 онд 1 удаа хуралдаж 15.0 сая төгрөгийн автобус худалдан авах, 25.0 сая төгрөгийн ""Ахмад залуучуудын төв"-ийн урд талбайн тохижилтын ажлыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн ч "Ахмад залуучуудын төв"-ийн тохижилтын ажил хэрэгжээгүй байна.

Мандал, Баянгол сумдын хороод нь 2018, 2019 онуудад төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдалд улирал тутам хяналт, шалгалтыг хэрэгжүүлээгүй, хяналт шалгалтын хүснэгтийн дагуу дүгнээгүй, олон нийтэд хэрэгжилтийн талаар мэдээлэл хийгээгүй байгаа нь тус журмын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

2017-2019 онд 18 тусгай зөвшөөрөл эзэмшигч, 1 туслан гүйцэтгэгч компанитай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд нийт **2,758.5** сая төгрөгийн ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас **2,684.5** сая төгрөгийн ажил, арга хэмжээг хэрэгжүүлж, дараах компаниуд гэрээнд тусгагдсан нийт **74.0** сая төгрөгийн 4 ажил төсөл, арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- *“Бороо гоулд” ХХК, Баянгол сумын Засаг дарга нарын 2019 онд байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан 24.0 сая төгрөгийн Ахмад, залуучуудын төвийн урд талбайн тохижилтын ажил;*
- *“Демси трейд” ХХК, Мандал сумын Засаг дарга нарын 2018 онд байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан 10.0 сая төгрөгийн хурд сааруулагч, камержуулалт, замын тэмдэг, тэмдэглэгээний ажил;*
- *“Олз газар” ХХК, Сэлэнгэ аймгийн Засаг дарга нарын 2019 онд байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан 20.0 сая төгрөгийн Орхон суманд ёслол хүндэтгэлийн өргөө барих ажил;*
- *“Хонгорын орд” ХХК, Баянгол сумын Засаг дарга нарын байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан 20.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт зэрэг болно.*

2017-2019 онд үйл ажиллагаа явуулсан нийт 25 компаниас 16 компани, туслан гүйцэтгэгч 1 компани аймаг, сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулан ажилласнаас 9 компанийн гэрээнд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах хувь, хэмжээг зааж өгсөн байна. Гэвч аудитын явцад хэрэгжилтийг шалгахад **5** компанитай хийсэн гэрээний заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд: */Дэлгэрэнгүйг хавсралт № 2-т харуулав/*

- *Баянгол сумын Засаг дарга, “Хонгорын орд” ХХК-тай 2018 онд байгуулсан гэрээнд нийт ажлын байрны 20-иос доошгүй хувьд орон нутгийн иргэдийг авч ажиллуулахаар тусгасан ч 13.2 хувьд л орон нутгийн иргэдийг ажиллуулсан;*
- *Орхонтуул сумын Засаг дарга, “Өгөөж баян хангай” ХХК, “Бийд майнинг” ХХК-уудтай байгуулсан гэрээнүүдэд нийт ажлын байрны 5-аас доошгүй хувьд орон нутгийн иргэдийг авч ажиллуулахаар тусгасан ч огт хэрэгжүүлээгүй;*
- *Түшиг сумын Засаг дарга, “Шар нарст” ХХК-тай 2019 онд байгуулсан гэрээнд нийт ажлын байрны 30-аас доошгүй хувьд орон нутгийн иргэдийг авч ажиллуулахаар тусгасан ч 22.8 хувьд, “Редхил монголиа” ХХК-ийн туслан гүйцэтгэгч “Техно преспектив” ХХК-тай байгуулсан гэрээнд нийт ажлын байрны 60-аас доошгүй хувьд орон нутгийн иргэдийг авч ажиллуулахаар тусгасан ч 53.3 хувьд л тус тус орон нутгийн иргэдийг авч ажиллуулсан байна.*

Харин 8 компанитай байгуулсан гэрээнд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах хувь, хэмжээг тодорхой заагаагүй байна.

2017-2019 онд Сэлэнгэ аймаг, 5 сумын Засаг дарга нар нийт 19 компанитай 26 гэрээ байгуулан ажилласан ч гэрээний хэрэгжилтийн тайланг дүгнээгүй, сумын ИТХ, дээд шатны Засаг дарга болон Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гэрээнд заасан хугацаанд хүргүүлээгүй байгаа нь хамтын ажиллагааны гэрээний 5.1-5.3 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

**Бүлэг 2**

**Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс хууль, журмын хүрээнд хандив, тусламжийн орлого төвлөрүүлэн, зарцуулж байна уу?**

*Нийт хандив, тусламжийн 85.9 хувь нь Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-д заасан зорилго, агуулгатай нийцээгүй байна.*

## *2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудаас хууль, журмын хүрээнд хандив, тусламжийн орлого төвлөрүүлж байна уу?*

*Хандив, тусламжийн орлогыг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлээгүй байна.*

2017-2019 онуудад 36 уул уурхайн компаниас орон нутгийн захиргааны байгууллагуудад нийт **4,425.6** сая төгрөгийн хандив, тусламж өгсний **2,684.5** сая төгрөг нь аймгийн болон 5 сумдын Засаг дарга нарын 18 компанитай байгуулсан гэрээний дагуу өгсөн хандив, тусламж, **1,741.1** сая төгрөг нь гэрээ байгуулалгүйгээр 30 компаниас 10 сум болон аймгийн ОБГ, БОАЖГ, ЗӨСТ, Нэгдсэн эмнэлэг зэрэг байгууллагуудад өгсөн хандив, тусламж байгаа бол 30.2 хувь болох 1,335.0 сая төгрөгийг мөнгөн хэлбэрээр, 69.8 хувь болох 3,090.6 сая төгрөгийг мөнгөн бус хэлбэрээр өгсөн байна. / *Дэлгэрэнгүй хавсралт № 3, 4-т харуулав* /

Гэрээний дагуу өгсөн хандив тусламжийг 2017-2019 оны байдлаар харуулбал:

График-3




Гэрээ байгуулсны үндсэн дээр өгсөн нийт 2,684.5 сая төгрөгийн хандив тусламжийн 52.7 хувийг Баянгол сум, 32.6 хувийг аймаг, 6.7 хувийг Түшиг сум, 5.0 хувийг Мандал сум, 1.9 хувийг Хүдэр сум, 1.1 хувийг Орхонтуул сум тус тус эзэлж байгаа бөгөөд 946.5 сая төгрөгийг мөнгөн хэлбэрээр, 1,738. 5 сая төгрөгийг хөрөнгөөр буюу үйлчилгээгээр үзүүлсэн байна.

Мөнгөн хэлбэрээр олгосон 869.5 сая төгрөгөөс 700.0 сая төгрөгийг аймгийн ОНХС-ийн дансанд, 10.0 сая төгрөгийг Мандал сумын татварын орлогын дансанд, 28.5 сая төгрөгийг төсвийн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд, 98.5 сая төгрөгийг ТББ-ын дансанд, 32.5 сая төгрөгийг хувь хүний дансанд тус тус шилжүүлсэн байна.

Гэрээ байгуулалгүйгээр 10 сум болон 4 байгууллагад хандивласан нийт **1,741.1** сая төгрөгийн 26.7 хувь болох 465.5 сая төгрөгийг мөнгөн хэлбэрээр, 73.3 хувь болох 1,275.6 сая төгрөгийг хөрөнгө, үйлчилгээгээр өгсөн байна.

**Гэрээ байгуулалгүйгээр өгсөн хандив, тусламж**

/сая төгрөгөөр/ Хүснэгт-2

| № | Сум, байгууллагын нэр | 2017 он | | 2018 он | | 2019 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Мөнгөн | Мөнгөн бус | Мөнгөн | Мөнгөн бус | Мөнгөн | Мөнгөн бус |
| 1 | БОАЖГ | | | | | | 3.0 |
| 2 | ЗӨСТ | 2.0 | | | | | |
| 3 | Нэгдсэн эмнэлэг | | 200.0 | | | | |
| 4 | Аймгийн ОБГ | 10.0 | 5.0 | 10.0 | | | |
| 5 | Баянгол | 3.5 | 8.3 | - | - | 107.0 | 120.4 |
| 6 | Ерөө сум | | 121.0 | 11.0 | 578.7 | 39.4 | 115.4 |
| 7 | Жавхлант сум | 10.0 | | | 15.0 | 5.0 | |
| 8 | Мандал сум | 10.1 | 40.2 | 13.2 | | | 6.2 |
| 9 | Орхонтуул | 1.5 | 5.2 | 13.0 | 5.4 | | |
| 10 | Сант | | | | 1.1 | | |
| 11 | Сүхбаатар сум | 100.0 | | | | | |
| 12 | Түшиг | 4.0 | 6.2 | 5.0 | 14.5 | | |
| 13 | Хушаат сум | | | | | 120.0 | |
| 14 | Хүдэр | | 30.0 | 0.8 | | | |
| **Нийт дүн** | | **141.1** | **415.9** | **53.0** | **614.7** | **271.4** | **245.0** |

Гэрээ байгуулалгүйгээр өгсөн нийт хандив, тусламжийн 49.7 хувийг Ерөө сум, 13.7 хувийг Баянгол сум, 11.5 хувийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, 6.9 хувийг Хушаат сум, 5.7 хувийг Сүхбаатар сум, 12.5 хувийг бусад 6 сум, 3 байгууллага эзэлж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-д *"Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана"*, Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор баталсан ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах гэрээний загварын 1 дүгээр зүйлд заасан Нийтлэг үндэслэлийн 1.1-д *"Энэхүү гэрээ нь .............Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч* ***байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх*** *асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна"* гэж заасан байдаг.

Гэвч нийт олгосон хандив тусламжийн **3,801.5** сая төгрөг буюу **85.9** хувийг байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр бус хөрөнгө оруулалт, урсгал засвар, тохижилт, эд хогшил худалдан авах, баяр ёслол, ойн арга хэмжээ тэмдэглэх зэрэг чиглэлээр төвлөрүүлсэн байна. */Дэлгэрэнгүйг хавсралт №6-д харуулав/*

График-4




Нөгөө талаас Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т *“Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно: 25.2.1.**эмнэлгийн үйлчилгээ**; 25.2.2.**бүх шатны боловсролын үйлчилгээ**; 25.2.3.**соёлын үйлчилгээ**”* гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл Төсвийн тухай хуулиар эмнэлэг, боловсрол, соёлын чиглэлийн байгууллагууд хандив тусламж авч болохоор, бусад төсвийн байгууллагуудын урсгал зардалд хандив тусламж төвлөрүүлэхгүй байхаар зохицуулагдсан байна.

Гэтэл Төсвийн тухай хуулийн дээрх заалтыг зөрчин 2017-2019 онд аймгийн БОАЖГ болон 6 сумдын байр, авто машины урсгал засвар, байгууллагын ой тэмдэглэх, уралдаан, тэмцээн, баяр наадмын зардал, сургалтын зардал гэх мэт урсгал зардалд **108.9** сая төгрөгийн мөнгөн, **26.2** сая төгрөгийн мөнгөн бус хандив, тусламж авсан байна.

**Хандив, тусламжийн хэмжээг сумдаар харуулбал /2017-2019 он/**

График-5




Төсвийн тухай хууль зөрчин уул, уурхайн компаниудаас авсан нийт хандив, тусламжийн 39.6 хувийг Баянгол сум, 24.2 хувийг Ерөө сум, 14.9 хувийг Мандал сум, 11.1 хувийг Орхонтуул сум, 6.7 хувийг Түшиг сум, 2.2 хувийг аймгийн БОАЖГ, 1.3 хувийг Хүдэр сум тус тус эзэлж байна.

Хууль зөрчин авсан нийт хандив тусламжийн 55.1 хувийг баяр наадам, уралдаан тэмцээн, 18.2 хувийг урсгал засвар, 13.2 хувийг сургалт, зөвлөгөөн, 10.0 хувийг гамшиг, 3.5 хувийг эрүүл мэндийн үзлэгтэй холбоотой хандив, тусламж эзэлж байна. */Дэлгэрэнгүйг хавсралт №5-д харуулав/*

Харин тус хуулийн 60 дугаар зүйлийн дагуу орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий хөрөнгө оруулалтын чиглэлийн хандив, тусламжийг ОНХС-ийн эх үүсвэр байхаар буюу тус хуулийн 60.2-д "*Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 60.2.5.тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон* ***дотоод, гадаадын хандив, тусламж****, ...*" гэж заасны дагуу ОНХС-ийн дансанд төвлөрүүлж, уг санг зарцуулах хууль, журмын дагуу зарцуулах ёстой.

Гэтэл орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий хөрөнгө оруулалтын шинж чанартай нийт **1,239.8** сая төгрөгийн хандив, тусламжийг ОНХС-ийн дансанд төвлөрүүлэлгүйгээр шууд гүйцэтгэгч компанийн данс, төсвийн байгууллагын нэмэлт санхүүжилтийн данс, төрийн бус байгууллагын данс болон ОНӨААТҮГ-ын дансанд төвлөрүүлэн, зарцуулсан байна. Үүнд:

- *Аймаг, Баянгол, Ерөө, Мандал, Түшиг, Хүдэр сумд 21 төсөл, арга хэмжээний нийт 1,103.8 сая төгрөгийг гүйцэтгэгч компанийн дансанд;*
- *Орхонтуул сум 1 төсөл, арга хэмжээний 10.0 сая төгрөгийг сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд;*
- *Ерөө сум 1 төсөл, арга хэмжээний 11.0 сая төгрөгийг "Төгөлдөр ерөө" ОНӨААТҮГ-ын дансанд;*
- *Сүхбаатар, Баянгол сумд 2 төсөл, арга хэмжээний 115.0 сая төгрөгийг "Сүхбаатар хөгжлийн төлөө" ТББ, "Баян хөгжил сан" ТББ-уудын дансанд тус тус төвлөрүүлэн, хэрэгжүүлсэн байна.*

Мөн **41.5** сая төгрөгийн хандив тусламжийг албан тушаалтны хувийн харилцах дансанд төвлөрүүлэн, зарцуулсан байна. Үүнд:

- *Аймгийн Засаг дарга, “Тайхаржин майнинг” ХХК-тай 2019 онд байгуулсан гэрээний дагуу Сүхбаатар сумын 2-р сургуулийн тохижилтын ажилд олгосон 15.0 сая төгрөгийн хандив, тусламжийг сургуулийн захирлын хувийн дансаар;*
- *Аймгийн Засаг дарга, “Шар нарст” ХХК-тай 2019 онд байгуулсан гэрээний дагуу Нэгдсэн эмнэлэгт тоног төхөөрөмж, Сүхбаатар сумын 1-р цэцэрлэгийн тохижилт, “Сэлүүн дэнжийн яргуй” дууны клип хийлгэх ажлуудад нийт 10.0 сая төгрөгийн хандив, тусламжийг аймгийн ЗДТГ-ын нярвын дансаар;*
- *Баянгол сумын Засаг дарга, “Бороо гоулд” ХХК-тай 2019 онд байгуулсан гэрээний дагуу “Атар 60 жил” ойн арга хэмжээнд зориулан олгосон 7.5 сая төгрөгийн хандив, тусламжийг сумын Хөдөө, аж ахуйн тасгийн мэргэжилтний дансаар;*
- *“Шар нарст” ХХК-аас Түшиг сумын Засаг даргатай гэрээ байгуулалгүйгээр 2017 онд олгосон 4.0 сая, 2018 онд олгосон 5.0 сая төгрөгийн хандив, тусламжийг сумын Санхүүгийн албаны даргын хувийн дансаар тус тус авч, зарцуулсан байна.*

Сэлэнгэ аймаг нь Атар-60 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой “Атрын нутгийн хөгжил” ТББ-ыг байгуулан, “Болд төмөр ерөө гол” ХХК-ийн Ерөө баянгол сантай зээлийн гэрээ байгуулан **120.0** сая төгрөгийг 6 сарын хугацаатайгаар авч ойн арга хэмжээнд зарцуулсан боловч гэрээний хугацаанд барагдуулаагүй байгаа нь 2019 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр байгуулсан зээлийн гэрээний 3.1-д “*Зээлийн хугацаа нь 2019 оны 11 сарын 27-ны өдрөөс 2020 оны 5 сарын 01 хүртэл 6 сар байна*” гэж заасныг зөрчсөн байна.

### *2.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудаас өгсөн хандив, тусламжийг хууль, журам, гэрээ, зориулалтын дагуу зарцуулж байна уу?*

*Хандив, тусламжийн орлогыг холбогдох хууль, эрхийн актын дагуу зарцуулаагүй байна.*

Аудитын явцад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудаас орон нутгийн захиргааны байгууллагуудад хамтын ажиллагааны хүрээнд өгсөн хандив, тусламжийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа, бүртгэл тайланд тусгасан байдлыг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

**1.** Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудаас төвлөрүүлсэн хандив, тусламжийн орлогыг гэрээнд заасан зориулалт бусаар зарцуулсан **75.0** сая төгрөгийн зөрчил илэрсэн нь хамтран ажиллах гэрээний холбогдох заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- *Баянгол сумын Засаг дарга, “Сонор трейд” ХХК-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд сумын дэд бүтцийг хөгжүүлж, ажлын байр нэмэгдүүлэхэд зориулж 50.0 сая төгрөгийн хандив, тусламж олгосныг*

*Баянгол сумын “Баян хөгжил сан” ТББ-ын дансаар дамжуулан Мандал сумын Цагдаагийн хэлтсийн ахмадын зөвлөл” ГҮТББ-д бэлнээр олгож, Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн 60 жилийн ойн арга хэмжээнд зарцуулсан;*

- *Мандал сумын Засаг дарга, “Демси трейд” ХХК-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хурд сааруулагч, камержуулалт, замын тэмдэг, тэмдэглэгээ хийхэд зориулж 25.0 сая төгрөгийн хандив, тусламж өгснөөс 10.0 сая төгрөгийг сумын хүү, торгуулийн орлогын дансанд төвлөрүүлж, 15.0 сая төгрөгийг сумын ЗДТГ-ын байрны гадна фасадын ажилд тус тус зарцуулсан байна.*

**2.** Хандив, тусламжийн эх үүсвэрээр хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ шууд худалдан авах босго үнээс давсан худалдан авах ажиллагааг харьцуулалтын болон нээлттэй тендер шалгаруулах аргаар зохион байгуулаагүй **157.5** сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн *8.4-т ”Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”*-ийн 1-т *“Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 80.0 (ажил) сая төгрөг”,* 2-т “*Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 10.0 сая төгрөг*” гэж заасныг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- *Аймгийн Засаг дарга, “Тайхаржин майнинг” ХХК-тай 2019 онд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу олгосон 15.0 сая төгрөгийн хандив, тусламжаар гүйцэтгэсэн Сүхбаатар сумын 2-р сургуулийн гадна тохижилтын ажил,*
- *Мандал сумын Засаг дарга, “Бороо гоулд” ХХК-тай 2019 онд байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд 2 талын хамтын ажиллагааны хорооны шийдвэрийн дагуу олгосон 15.0 сая төгрөгийн хандив, тусламжаар гүйцэтгэсэн 50-р байрны гадна фасад засвар-ын ажил,*
- *“Болд төмөр ерөө гол” ХХК-ийн Ерөө, баянгол сангаас Ерөө суманд 2019 онд олгосон 11.0 сая төгрөгийн хандив, тусламжаар гүйцэтгэсэн Буурагчин багийн улаан булангийн байрны засварын ажил;*
- *Баянгол сумын Засаг дарга, “Бороо гоулд” ХХК-тай 2019 онд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу олгосон 15.0 сая төгрөгийн Автобус худалдан авах ажил;*
- *Баянгол сумын Засаг дарга, “Сэлэнгэ байгалийн нөөц” ХХК-тай 2019 онд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу олгосон 87.0 сая төгрөгийн Ерөнхий боловсролын сургуулийн гадна фасадын ажил;*
- *“Шар нарст” ХХК-иас Түшиг суманд 2018 онд олгосон 14.5 сая төгрөгийн хандив, тусламжаар гүйцэтгэсэн орон нутаг судлах танхимын барилга худалдан авах ажлууд зэрэг болно.*

**3.** Хандив тусламжийн хөрөнгийн зарцуулалтын **153.3** сая төгрөгийн ажил гүйлгээ нь гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад баримтаар бүрэн

нотлогдохгүй *байгаа нь* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг знэн, зөв гаргах үндэслэл болно "* гэж заасныг зөрчсөн байна. Үүнд:

- *Аймгийн Засаг дарга, "Шар нарст" ХХК-тай 2019 онд байгуулсан гэрээний дагуу "Сэлүүн дэнжийн яргуй" дууны клип хийлгэхэд өгсөн 5.0 сая төгрөг;*
- *Баянгол сумын Засаг дарга, "Бороо гоулд" ХХК-тай 2019 онд байгуулсан гэрээний дагуу Атар-60 жилийн ойн арга хэмжээнд зориулж, "Баян хөгжил сан" ТББ-д өгсөн 30.0 сая төгрөг;*
- *"Сэлэнгэ байгалийн нөөц" ХХК-аас 2019 онд Баянгол сумын "Баянгол хөгжлийн гүүр" ОНӨААТҮГ-т сургуулийн гадна фасадын засварт өгсөн 87.0 сая төгрөг;*
- *"Өгөөж баянхангай" ХХК-аас 2017 онд Орхонтуул суманд өгсөн 5.0 сая төгрөг;*
- *"Шар нарст" ХХК-аас Түшиг суманд 2017 онд өгсөн 2.9 /нийт 5.0 сая/ сая төгрөг, 2018 онд өгсөн 1.4 /нийт 4.0 сая/ сая төгрөг;*
- *"Болд төмөр ерөө гол" ХХК-ийн Ерөө баянгол сангаас 2019 онд Атар-60 жилийн ойн арга хэмжээнд зориулан Жавхлант суманд өгсөн 5.0 сая төгрөг, Ерөө суманд өгсөн 17.0 сая төгрөгийн тус тус зарцуулалт нь анхан шатны баримтаар бүрэн нотлогдохгүй байна.*

**4.** Уул, уурхайн 10 аж ахуйн нэгжээс 4 суманд өгсөн **1,662.7** сая төгрөгийн хандив, тусламжийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д *"нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;14.4.5 "бүх орлого"* гэж заасныг тус тус зөрчсөн бөгөөд хөрөнгө үрэгдэн шамшигдах эрсдэлийг үүсгэж байна. Үүнд:

- *Баянгол сум 2018-2019 онд "Тод ундрага" ХХК, "Сэлэнгэ байгалийн нөөц" ХХК-уудаас хандив, тусламжаар авсан 1,294.1 сая төгрөгийн 2 хөрөнгө;*
- *Ерөө сум 2017-2019 онд "Болд төмөр ерөө гол"-ийн Ерөө, баянгол сангаас хандив, тусламжаар авсан 288.6 сая төгрөгийн 7 хөрөнгө;*
- *Хүдэр сум 2017-2018 онд "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК, "Эрдэс групп" ХХК, "Уулс ноён" ХХК-уудаас хандив, тусламжаар авсан 80.0 сая төгрөгийн 3 хөрөнгийг тус тус бүртгэл тайландаа тусгаагүй байна.*

Дараах 4 сумд 5 уул, уурхайн компанийн хандив, тусламжаар гүйцэтгэсэн **165.0** сая төгрөгийн нийт 6 хөрөнгийг ажил нь дуусаагүй, комиссоор хүлээж аваагүй гэсэн шалтгаанаар бүртгэл тайланд орлого аваагүй байна. Үүнд:

- *"Бороо гоулд "ХХК-иас Мандал суманд өгсөн хандив, тусламжаар гүйцэтгэж байгаа 8.0 сая төгрөгийн үерийн далангийн ажил;*
- *"Пентатерра" ХХК-аас Баянгол суманд өгсөн хандив, тусламжаар гүйцэтгэж байгаа 62.0 сая төгрөгийн уурын зуухны засварын ажил;*
- *"Болд төмөр ерөө гол" ХХК-аас Ерөө суманд өгсөн хандив, тусламжаар гүйцэтгэж байгаа 10.0 сая төгрөгийн спорт заалны засварын ажил, 35.0 сая төгрөгийн цэцэрлэгийн барилгын ажил;*

- *“Ди Зэт Энд Ай” ХХК-аас аймагт өгсөн хандив, тусламжаар Шаамар суманд гүйцэтгэж байгаа 20.0 сая төгрөгийн партизаны хөшөөний ажил;*
- *“Эрдэс групп” ХХК-аас аймагт өгсөн хандив, тусламжаар Шаамар суманд гүйцэтгэж байгаа 30.0 сая төгрөгийн гудамжны гэрэлтүүлгийн ажлууд тус тус байна.*

“Бороо гоулд” ХХК, “Сентерра гоулд” ХХК-уудаас 2018-2019 онд хандив, тусламжаар өгсөн **49.0** сая төгрөгийн нийт 5 авто тээврийн хэрэгсэл нь Баянгол сумын “Баян хөгжил сан” ТББ-ийн эзэмшилд бүртгэлтэй байна.

## АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Нийцлийн аудитаар дараах **3,658.9** сая төгрөгийн алдаа, зөрчилд **албан шаардлага** */Дэлгэрэнгүйг хавсралт №7-д харуулав/* бичигдлээ. Үүнд:

- Аймаг, Баянгол, Ерөө, Мандал, Орхонтуул, Түшиг, Хүдэр сумд нь Төсвийн тухай хуулийг зөрчин байр, авто машины урсгал засвар, байгууллагын ой тэмдэглэх, уралдаан, тэмцээн, баяр наадмын зардал, сургалтын зардал гэх мэт урсгал зардалд **108.9** сая төгрөгийн мөнгөн, **26.2** сая төгрөгийн мөнгөн бус хандив, тусламж авсан;
- Аймаг, Баянгол, Ерөө, Мандал, Сүхбаатар, Орхонтуул, Түшиг, Хүдэр сумд нь хөрөнгө оруулалтын шинж чанартай нийт **1,239.8** сая төгрөгийн хандив, тусламжийг аймаг, сумын ОНХС-ийн дансанд бус шууд гүйцэтгэгч компанийн данс, төсвийн байгууллагын нэмэлт санхүүжилтийн данс, төрийн бус байгууллагын данс, ОНӨААТҮГ-ын дансанд төвлөрүүлэн, хэрэгжүүлсэн;
- Аймаг, Баянгол, Түшиг сумд нь “Бороо гоулд”, “Шар нарст”, “Тайхаржин майнинг” ХХК-иудаас өгсөн нийт **41.5** сая төгрөгийн хандив, тусламжийг албан тушаалтнуудын хувийн дансаар дамжуулан, зарцуулсан;
- Аймаг, Баянгол, Мандал сумд 4 тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан нийт **74.0** сая төгрөгийн 4 ажил, арга хэмжээг хэрэгжүүлээгүй;
- Хамтын ажиллагааны гэрээний дагуу “Сонор трейд” ХХК-аас Баянгол суманд өгсөн 50.0 сая төгрөг, “Демси трейд” ХХК-аас Мандал суманд өгсөн 25.0 сая төгрөг, нийт **75.0** сая төгрөгийн хандив, тусламжийг зориулалт бусаар зарцуулсан;
